



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/04

Арвайхээр сум


**Газар ашиглалтын зориулалтад
өөрчлөлт оруулах тухай**

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 5 дугаар баг, Шинэ-Арвайхээр-2 гудамж, 235а тоотод байрлах Өв хангамж групп ХХК-ийн (3556034) эзэмшил худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай 19308м² газар, 5 дугаар баг, Шинэ-Арвайхээр-2 гудамж, 235б тоотод байрлах Өв хангамж групп ХХК-ийн (3556034) эзэмшил худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай 14042м² газрын зориулалтыг тус тус үйлчилгээтэй орон сууцны зориулалттай болгон өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0009